

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

2024 оны 10 дугаар сарын хүлээгдлийн мэдээг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал, Хүрээ амаржих газар, Геронтологийн үндэсний төв ирүүлсэн болно.

1. Улсын нэгдүгээр төв эмнэлэг

Тус эмнэлэгт мэргэжлийн эмчид үзүүлэхээрнийт 304 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	Нийт
1	Хэрх үе судлал	-	-	79	79
2	Нүд судлал	-	-	67	67
3	Урологи	-	-	31	31
4	Мэдрэл судлал	-	11	-	11
5	Хоол боловсруулах эрхтэн судлал	-	16	-	16
6	Бөөр судлал	-	-	25	25
7	Булчирхай судлал	-	-	23	23
8	Цусны эмгэг судлал	-	-	25	25
9	Чих хамар хоолой судлал	-	-	17	17
10	Ндний даралт	-	-	9	9
11	Эрүү нүүрний мэс засал	-	1	-	1
	НИЙТ	-	28	276	304

Хэрх үе судлалд үзүүлэхээр 79, нүдний эмчид үзүүлэхээр 67 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Оношилгооны чиглэлээр эмнэлгийн хүлээгдэл маш их, КТГ шинжилгээ хийлгэх шаардлагатай эмчлүүлэгчийн тоо нийт 216 байгаа бөгөөд өргөтгөлийн КТГ аппарат эвдэрсэн тул хүлээгдэл нэмэгдсэн байна. Өнөөдрийн байдлаар 2024.11.12-ний цаг тараагдаж байна. Түүнчлэн MRI шинжилгээ хийлгэхээр нийт 40 хүн 15-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

2024 оны 10 сард тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмнэлгийн хэмжээнд нийт 1675 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн орны хүлээгдэлтэй байгаа нь өмнөх сараас 300 гаруй үйлчлэгчээр нэмэгдсэн байна. Хүснэгт 2.

Хүснэгт 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Нүд судлал	9	84	64	983	1140
2	Чих, хамар, хоолой судлал	23	48	91	162	324
3	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	2	6	34	59	101
4	Урологи	10	34	14	-	58
5	Цусны эмгэг судлал	2	6	-	-	8
6	Хоол боловсруулах эрхтэн судлал	6	4	1	-	11
7	Дотоод шүүрэл судлал	1	3	1	-	5
8	Мэс засал судлал	13	9	2	-	24
9	Зүрх судас	2	1	-	-	3
10	Мэдрэл судлал	1	-	-	-	1
	НИЙТ	69	195	207	1204	1675

Болорын мэс заслын хүлээгдэл ихтэй байгаа ба нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1140, Чих, хамар, хоолойн тасагт хэвтэн эмчлүүлэхээр 324 үйлчлүүлэгч буюу хамгийн их хүлээгдэлтэй байна. Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1140 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн талаас илүү 68% -ийг эзэлж байна. Мөн хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 72% нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна.

2. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх сараас нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 2024 оны 10 сарын 28-ны өдрийн байдлаар нийт 202 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэлтэй байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчийн үзлэг орж байна. Хүснэгт 3.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	2	7	43	52
2	Мэс засал судлал	8	1	21	30
3	Мэдрэл судлал	1	18	22	41

4	Зүрх судас	1	20	4	25
5	Уушиг судлал	2	17	4	23
6	Нүд судлал	1	1	17	18
7	Чих хамар хоолой судлал	2	3	5	10
8	Эмэгтэйчүүд судлал	-	-	3	3
	НИЙТ	17	67	119	202

Нийт хүлээгдлийн талаас илүү буюу 59% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 121 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эход харуулахаар 58, рентген оношилгоо хийлгэхээр 47, MRI оношилгоо хийлгэхээр 14 үйлчлүүлэгч тус тус 2-с дээш хоног хүлээж байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Хэвлийн эхо	19	5	34	58
2	Рентген зураг	9	10	28	47
3	MRI/CT	-	1	13	14
4	ЭКГ	2	-	-	2
	Бүгд	30	16	75	121

Тус эмнэлэгт лабораторийн шинжилгээний хүлээгдэл 10 сард огцом өсөж, нийт 121 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Хэвлийн эхо хийлгэхээр 58, Рентген зураг авахуулахаар 47 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд хамаарч байна. Тус эмнэлэгт лабораторийн тусламж, үйлчилгээ авахаар 121 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Хүснэгт 5.

Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа		
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног
1	Бактерлогийн шинжилгээ	5	1	1
2	Биохимийн шинжилгээ	4	-	11
3	Серологи	12	-	2
4	Иммунологи	82	-	3
	НИЙТ	103	1	17

Иммунологийн шинжилгээ хийлгэхээр 82 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Тус эмнэлгийн орны хүлээгдэл өмнөх саруудаас огцом өсч, нийт 551 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 288 хүн, Чих, хамар, хоолой судлалын тасагт хэвтэхээр 130 үйлчлүүлэгч ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 6.

Хүснэгт 6. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				БҮГД
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	20	63	78	127	288
2	Чих, хамар, хоолой судлал	10	15	25	80	130
3	Мэс засал судлал	25	22	-	-	47
4	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	5	10	3	-	18
5	Уламжлалт эмчилгээний тасаг	4	10	10	-	24
6	Мэдрэлийн эмгэг судлал	6	13	-	-	19
7	Урологи	4	10	10	-	24
8	Зүрх судас	1	-	-	-	1
	НИЙТ	75	143	126	207	551

3. Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж үйлчилгээний хүлээгдэл өмнөх саруудаас нэмэгдсэн, нийт 475 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3 ба түүнээс дээш хоног хүлээж байна. Хүснэгт 7.

Хүснэгт 7. Улсын гуравдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Зүрхний эмгэг судлал	5	7	92	104
2	Мэдрэл судлал	3	2	80	85
3	Зүрхний мэс засал судлал	1	6	40	47
4	Бөөр судлал	3	13	40	56
5	Нүд судлал	1	1	25	27
6	Чих хамар хоолой судлал	-	2	25	27
7	Хоол боловсруулах эрхтэн судлал	3	4	31	38
8	Мэс засал судлал	1	2	21	24
9	Мэдрэлийн мэс засал	5	3	1	9
10	Урологи	2	-	20	22
11	Зүрх/ хэм алдагдал/	-	-	18	18
12	Уушиг судлал	2	2	3	7
13	Үе судлал	2	1	1	4
14	Уламжлалт	2	1	4	7
	НИЙТ	30	44	401	475

Зүрхний эмгэг судлалын эмчид үзүүлэхээр 104, Мэдрэлийн эмчид үзүүлэхээр 85 үйлчлүүлэгч тус бүр 3 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна. Хүлээгдлэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 84,4% (401) нь 7 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 184 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сарын үзүүлэлттэй адил түвшинд байна. Хүснэгт 8.

Хүснэгт 8. Улсын гуравдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Хэвлийн эхо	3	30	25	58
2	Зүрхний эхо	1	1	48	50
3	Зүрхний цахилгаан бичлэг	8	3	13	24
4	Дуран	1	1	19	21
5	Холтер	-	-	13	13
6	Доплер	1	3	4	8
7	Рентген зураг	3	2	1	6
8	Тархины цахилгаан бичлэг	1	2	1	4
	Бүгд	18	42	124	184

Хэвлийн эхо-д харуулахаар 58 үйлчлүүлэгч, зүрхний эхо-д харуулахаар 50 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд тус тус хамаарч байна. Үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 67,4% нь 15 ба түүнээс дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Харин тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ хүлээгдэл харьцангуй бага байна. Хүснэгт 9.

Хүснэгт 9. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа	
		3-6 хоног	7-14 хоног
1	Цусны шинжилгээ	10	3
2	Бактерлогийн шинжилгээ	7	-
3	Биохимийн шинжилгээ	10	3
4	Шээсний шинжилгээ	2	-
5	Иммунологи	4	
	НИЙТ	33	6

Цусны, биохимийн шинжилгээ хийлгэхээр тус тус 13 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэл шинжилгээнд хамаарч байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 254 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Мэдрэлийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 107, Нүдний тасагт хэвтэхээр 44 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их орны хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 10.

Хүснэгт 10. Улсын гуравдугаар төв эмнэлгийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	15
		7-14хоног	24
		15-30 хоног	22
		1 сараас дээш	46
		Нийт	107
3	Мэдрэлийн тасаг	3-6 хоног	4
		7-14хоног	5
		Нийт	9
4	Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасаг	3-6 хоног	3
		7-14хоног	2
		15-30 хоног	1
		Нийт	6
5	Нүдний тасаг	3-6 хоног	5
		7-14хоног	10
		15-30 хоног	9
		1 сараас дээш	20
		Нийт	44
7	Уламжлалт эмчилгээний тасаг	3-6 хоног	3
		7-14хоног	1
		15-30 хоног	2
		Нийт	6
8	Бөөр судлалын тасаг	3-6 хоног	5
		7-14хоног	3
		Нийт	8
9	Зүрх, судасны мэс засал	3-6 хоног	5
		7-14хоног	16
		15-30 хоног	10
		Нийт	31
10	Зүрх судасны тасаг	3-6 хоног	7
		7-14хоног	10
		15-30 хоног	18
		Нийт	35
11	Мэс заслын тасаг	3-6 хоног	3
		7-14хоног	5
		Нийт	8
	БҮГД	3-6 хоног	50
		7-14хоног	76
		15-30 хоног	62
		1 сараас дээш	66

		Нийт	254
--	--	-------------	------------

4. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 145 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 100 орчим үйлчлэгчээр буурсан үзүүлэлттэй байна. Гар сарвууны бичил мэс заслын эмчид үзүүлэхээр 35, нурууны мэс засалд үзүүлэхээр 34 үйлчлүүлэгч тус тус хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарна. Хүснэгт 11.

Хүснэгт 11. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Гар сарвууны бичил мэс заслын кабинет	11	19	5	35
2	Нурууны мэс засал	1	30	3	34
3	Хүүхдийн мэс заслын кабинет	17	4	1	22
4	Насанд хүрэгсдийн мэс засал	16	4	7	27
5	Толгойн мэс засал	4	1	3	8
6	Сэргээн засах эмчилгээ	-	-	16	16
7	Ясны эмгэгийн мэс засал	-	-	1	1
8	Зүрх судасны эмчийн үзлэг	-	1	-	1
9	Нөхөн сэргээх мэс засал	1	-	-	1
	НИЙТ	50	59	36	145

ГССҮТ-ийн MRI оношилгооны багаж гэмтэлтэй байгаа учир оношилгоо хийгдэхгүй байна. Харин КТГ+д харуулахаар 26 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд хүлээгдэл багатай, 2 үйлчлүүлэгч 3-6 хоног ор хүлээж байна.

5. Арьсны өвчин судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн үзлэг болон оношилгоо хүлээгдэлгүй байна. Харин Арьс харшлын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 24, MRSA эмчилгээ хийлгэхээр 7 үйлчлүүлэгч тус тус 3-6 хоног ор хүлээж байна.

6. Геронтологийн үндэсний төв

Тус төвд амбулаторийн үзлэг хийлгэхээр 8 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж байна.

7. Хүүхдийн төв сувилал, Хүрээ амаржих газар

2024 оны 10 сард хүлээгдэлгүй ажилласан байна.

8. Хавдар судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан, газрууд, Эх,

хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв болон Нийслэлийн эрүүл мэндийн газар нь 2024 оны 10 сарын хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.